



УУЛ УУРХАЙ,
ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМ

СТРАТЕГИ БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТИЙН ГАЗРЫН
ЭДИЙН ЗАСАГ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, СУДАЛГААНЫ ХЭЛТЭС

УУЛ УУРХАЙН САЛБАРЫН СТАТИСТИК МЭДЭЭЛЭЛ

2019 I-XI

I. УУЛ УУРХАЙН САЛБАРААС УЛСЫН ТӨСӨВТ ОРУУЛСАН ТАТВАР, ХУРААМЖ	1
II. АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАР	2
II.1. Аж үйлдвэрийн салбарын гол нэр төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл	2
II.2. Аж үйлдвэрийн салбарын нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэл	4
II.3. Аж үйлдвэрийн салбарын борлуулсан бүтээгдэхүүн.....	4
III. ГАДААД ХУДАЛДАА.....	6
III.1. Экспорт	6
III.2. Импорт	8



I. УУЛ УУРХАЙН САЛБАРААС УЛСЫН ТӨСӨВТ ОРУУЛСАН ТАТВАР, ХУРААМЖ

2018 оны жилийн эцсийн байдлаар улсын төсөвт **2,051.5** тэрбум төгрөгийг татвар, хураамж хэлбэрээр төвлөрүүлсэн байна. Үүнээс:

- Алт **80.0** тэрбум төгрөг,
- Нүүрс **910.6** тэрбум төгрөг,
- Цайр **76.9** тэрбум төгрөг,
- Зэс **871.9** тэрбум төгрөг,
- Төмөр **17.1** тэрбум төгрөг,
- Жонш **16.3** тэрбум төгрөг,
- Бусад **78.8** тэрбум төгрөг,

Улсын төсөвт орсон орлогыг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад **456.3** тэрбум төгрөг буюу **28.6** хувиар өссөн. Үүнээс:

- Алт **31.0 (63.1%)** тэрбум төгрөг,
- Нүүрс **306.8 (50.8%)** тэрбум төгрөг,
- Цайр **13.6 (21.5%)** тэрбум төгрөг,
- Зэс **71.1 (8.9%)** тэрбум төгрөг,
- Төмөр **4.7 (38.6%)** тэрбум төгрөг,
- Жонш **4.0 (32.1%)** тэрбум төгрөг,
- Бусад **25.0 (46.5%)** тэрбум төгрөг.

2019 оны эхний 11 сарын байдлаар улсын төсөвт **2,458.6** тэрбум төгрөг татвар, хураамж хэлбэрээр төвлөрүүлсэн байна. Үүнээс:

- Алт **112.5** тэрбум төгрөг,
- Нүүрс **1,175.2** тэрбум төгрөг,
- Цайр **65.2** тэрбум төгрөг,
- Зэс **981.7** тэрбум төгрөг,
- Төмөр **24.5** тэрбум төгрөг,
- Жонш **29.9** тэрбум төгрөг,
- Бусад **69.5** тэрбум төгрөг,

Улсын төсөвт оруулсан орлого өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад **518.6** тэрбум төгрөг буюу **26.7** хувиар өссөн байна. Үүнд:

- Нүүрс **329.4 (38.9%)** тэрбум төгрөг,
- Зэс **135.4 (16.0%)** тэрбум төгрөг,
- Алт **40.8 (56.8%)** тэрбум төгрөг,
- Жонш **15.2 (103.3%)** тэрбум төгрөг,
- Төмөр **8.3 (51.6%)** тэрбум төгрөг,

Харин дараах ашигт малтмалын татвар, хураамж буурсан үзүүлэлттэй байна. Үүнд:

- Цайр **7.8 (10.7%)** тэрбум төгрөг,
- Бусад **2.7 (3.7%)** тэрбум төгрөг.



II. АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАР

II.1. АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН ГОЛ НЭР ТӨРЛИЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ҮЙЛДВЭРЛЭЛ

2019 оны эхний 11 сарын гүйцэтгэлээр **47.87 сая тн** нүүрс, **1.17 сая тн** зэсийн баяжмал, **14.84 тн** алт, **4.79 мян.тн** молибдений баяжмал, **131.5 мян.тн** хайлуур жоншны хүдэр, **42.0 мян.тн** хайлуур жоншны баяжмал, **8.11 сая тн** төмрийн хүдэр, **3.06 сая тн** төмрийн хүдрийн баяжмал, **76.0 мян.тн** цайрын баяжмал, **6.32 сая бар** газрын тос тус тус үйлдвэрлэсэн байна.

Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад нүүрс **3.50 сая тн** буюу **7.9** хувь, төмрийн хүдэр **2.20 сая.тн** буюу **37.4** хувь, хайлуур жоншны хүдэр **33.2 мян.тн** буюу **33.8** хувь, газрын тос **539.8 мян.бар** буюу **9.3** хувиар тус тус өссөн байна.

Харин зэсийн баяжмал **33.2 мян.тн** буюу **2.8** хувь, алт **4.4 тн** буюу **22.9** хувь, молибдений баяжмал **266.5 тн** буюу **5.3** хувь, төмрийн хүдрийн баяжмал **94.5 мян.тн** буюу **3.0** хувь, хайлуур жоншны баяжмал **25.9 мян.тн** буюу **38.1** хувь, цайрын баяжмал **1.8 мян.тн** буюу **2.3** хувиар тус тус буурсан байна.

№	Бүтээгдэхүүний төрөл	Хэмжих нэгж	2018		2019		Өөрчлөлт			
			XI	I-XI	XI	I-XI	(5-3)=?, (5/3)=%	(6-4)=?, (6/4)=%		
	1	2	3	4	5	6	7	8	9	10
1	Уул уурхай, олборлох аж үйлдвэр									
1.1	Нүүрс	мян.тн	4,800.1	44,367.4	4,852.3	47,871.3	52.2	1.1%	3,503.9	7.9%
1.2	Газрын тос	мян.бар	569.7	5,777.7	579.9	6,317.5	10.2	1.8%	539.8	9.3%
1.3	Зэсийн баяжмал, м/агуулгаараа	мян.тн	115.3	1,204.6	96.3	1,171.4	-19.0	-16.5%	-33.2	-2.8%
1.4	Молибдений баяжмал, м/ агуулгаараа	тн	555.2	5,056.5	484.0	4,790.0	-71.2	-12.8%	-266.5	-5.3%
1.5	Алт	кг	1,760.7	19,237.3	1,690.3	14,836.4	-70.4	-4.0%	-4,400.9	-22.9%
1.6	Төмөр:									
	- Төмрийн хүдэр	мян.тн	556.4	5,900.9	644.9	8,105.2	88.5	15.9%	2,204.3	37.4%
	- Төмрийн хүдрийн баяжмал	мян.тн	291.5	3,150.4	365.1	3,055.9	73.6	25.2%	-94.5	-3.0%
1.7	Хайлуур жонш:									
	- Хайлуур жоншны хүдэр	мян.тн	4.3	98.3	10.7	131.5	6.4	2.5 ¹	33.2	33.8%
	- Хайлуур жоншны баяжмал	мян.тн	3.2	67.9	1.7	42.0	-1.5	-46.9%	-25.9	-38.1%
1.8	Цайрын баяжмал	мян.тн	8.0	77.8	7.5	76.0	-0.5	-6.3%	-1.8	-2.3%



2	Боловсруулах аж үйлдвэр									
2.1	Нүүрсэн шахмал түлш	тн	210.0	1,592.0	2,460.0	191,082.9	2,250.0	11.7 ¹	189,490.9	120.0 ¹
2.2	Катодын зэс, 99%	тн	1,289.9	12,997.3	912.3	10,826.2	-377.6	-29.3%	-2,171.1	-16.7%
2.3	Металл бэлдэц	тн	2,463.7	25,755.6	2,116.4	25,988.4	-347.3	-14.1%	232.8	0.9%
2.4	Металл цувимал	тн	3,298.4	29,424.9	-	23,586.7	-3,298.4	-100.0%	-5,838.2	-19.8%
2.5	Ган төмөр хийц	мян.тн	0.5	6.3	0.9	8.5	0.4	80.0%	2.2	34.9%
2.6	Цахилгааны утас	тн	2.3	80.1	4.7	81.2	2.4	2.0 ¹	1.1	1.4%

Эх сурвалж: ҮСХ

Тайлбар: ¹ - дахин их



II.2. АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН НИЙТ БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛДВЭРЛЭЛ

тэрбум төгрөг

Салбар	2018		2019		Өөрчлөлт			
	XI	I-XI	XI	I-XI	(4-2)=?, (4/2)=%	(5-3)=?, (5/3)=%		
1	2	3	4	5	6	7	8	9
Нийт дүн	1,384.0	14,223.9	1,463.5	16,039.9	79.5	5.7%	1,816.0	12.8%
Уул уурхай, олборлох аж үйлдвэр	987.4	10,245.4	1,011.3	11,610.2	24.0	2.4%	1,364.8	13.3%
Нүүрс олборлолт	346.1	3,572.5	387.2	4,932.5	41.1	11.9%	1,360.0	38.1%
Газрын тос олборлолт	84.2	919.6	87.9	937.6	3.7	4.4%	18.0	2.0%
Металлын хүдэр олборлолт	547.6	5,631.5	526.8	5,603.0	-20.9	-3.8%	-28.5	-0.5%
Бусад ашигт малтмал олборлолт	9.5	121.8	9.4	137.1	-0.1	-0.6%	15.3	12.6%
Боловсруулах аж үйлдвэр	296.9	3,044.3	330.2	3,358.8	33.4	11.2%	314.4	10.3%
Хүнд үйлдвэрийн салбар	80.4	906.2	110.7	1,051.8	30.2	37.6%	145.55	16.1%
Кокс, шахмал түлш үйлдвэрлэл	39.1	387.6	62.7	461.8	23.6	60.5%	74.3	19.2%
Химийн бүтээгдэхүүн үйлдвэрлэл	11.1	101.2	12.0	131.8	0.9	7.9%	30.6	30.3%
Төмөрлөг бүс эрдэс бодисоор хийсэн эдлэл үйлдвэрлэл	10.9	208.0	19.4	237.8	8.5	77.7%	29.8	14.3%
Төмрийн үйлдвэрлэл	18.6	197.7	16.3	211.0	-2.3	-12.6%	13.3	6.7%
Машин, тоног төхөөрөмжөөс бусад төмөр эдлэл үйлдвэрлэл	0.7	11.8	0.3	9.3	-0.4	-61.3%	-2.5	-20.9%

Эх сурвалж: УЦХ

Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл 2019 оны эхний 11 сарын гүйцэтгэлээр **16.0** их наяд төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс **1.8 (12.8%)** их наяд төгрөгөөр өслөө. Үүнд, уул уурхай, олборлох аж үйлдвэрийн нийт үйлдвэрлэл **11.6** их наяд төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс **1.4 (13.3%)** их наяд төгрөгөөр, үүнээс нүүрс олборлолт **1.4 (38.1%)** их наяд төгрөгөөр өссөн нь голлон нөлөөлсөн байна. Аж үйлдвэрийн салбарын нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэлд Уул уурхай, олборлох салбар **72.4** хувийг эзэлж байна.

II.3. АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН БОРЛУУЛСАН БҮТЭЭГДЭХҮҮН

тэрбум төгрөг

Салбар	2018		2019			Өөрчлөлт			
	XI	I-XI	XI	I-XI	Гад-дал	(4-2)=?, (4/2)=%	(5-3)=?, (5/3)=%		
1	2	3	4	5	6	7	8	9	10
Нийт дүн	1,560.0	16,450.3	1,520.7	18,369.6	12,502.5	-39.3	-2.5%	1,919.4	11.7%
Уул уурхай, олборлох аж үйлдвэр	1,134.2	11,367.8	952.9	12,572.4	10,439.8	-181.3	-16.0%	1,204.7	10.6%
Нүүрс олборлолт	314.1	3,732.2	201.8	4,658.1	4,257.5	-112.3	-35.7%	925.9	24.8%
Газрын тос олборлолт	103.2	899.4	81.7	889.7	889.7	-21.5	-20.9%	-9.7	-1.1%
Металлын хүдэр олборлолт	708.2	6,607.0	659.4	6,844.4	5,186.4	-48.8	-6.9%	237.4	3.6%
Бусад АМ олборлолт	8.7	129.1	10.0	180.2	106.2	1.3	14.9%	51.1	39.6%
Боловсруулах аж үйлдвэр	325.4	4,144.8	444.8	4,720.7	2,062.6	119.4	36.7%	575.9	13.9%
Хүнд үйлдвэрийн салбар	104.1	1,823.9	164.1	2,045.4	1,539.7	59.9	57.6%	221.5	12.1%



Кокс, шахмал түлш үйлдвэрлэл	48.2	1,154.8	91.6	1,267.6	1,257.5	43.4	90.0%	112.9	9.8%
Химийн бүтээгдэхүүн үйлдвэрлэл	11.3	103.8	12.8	140.6	-	1.4	12.5%	36.8	35.4%
Төмөрлөг бус эрдэс бодисоор хийсэн эдлэл үйлдвэрлэл	13.1	218.9	16.1	246.6	-	3.0	23.2%	27.7	12.7%
Төмрийн үйлдвэрлэл	30.5	336.5	43.1	381.8	280.5	12.7	41.6%	45.3	13.5%
Машин, тоног төхөөрөмжөөс бусад төмөр эдлэл үйлдвэрлэл	1.0	9.9	0.5	8.8	1.7	-0.6	-56.2%	-1.1	-11.5%

Эх сурвалж: УСХ

Аж үйлдвэрийн салбарын борлуулсан бүтээгдэхүүн 2019 оны эхний 11 сарын байдлаар **18.4** их наяд төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс **1.9 (11.7%)** их наяд төгрөгөөр өслөө. Үүнд, уул уурхай, олборлох аж үйлдвэрийн салбарын борлуулсан бүтээгдэхүүн **12.6** их наяд төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс **1.2 (10.6%)** их наяд төгрөгөөр, үүнээс нүүрс олборлолт **925.9 (24.8%)** их наяд төгрөгөөр, металлын хүдэр олборлолт **237.4 (3.6%)** тэрбум төгрөгөөр тус тус өссөн байна.

Аж үйлдвэрийн салбарын борлуулсан нийт бүтээгдэхүүнээс **12.5 (68.1%)** их наяд төгрөг, уул уурхай, олборлох аж үйлдвэрийн салбарын нийт бүтээгдэхүүнээс **10.4 (56.8%)** их наяд төгрөгийн бүтээгдэхүүнийг гадаад зах зээлд тус тус борлуулсан байна.



III. ГАДААД ХУДАЛДАА

Гадаад худалдааны нийт бараа эргэлт 2019 оны эхний 11 сарын байдлаар гүйцэтгэлээр **12,639.4** сая ам.долмарт хүрч өнгөрсөн оны мөн үеийнхээс **6.6** хувиар буюу **787.1** сая ам.доллараар өссөн байна. Экспорт импортоос давамгайлж экспорт, импортын зөрүү **1,471.8** сая ам.доллараар эерэг гарсан байна.

сая ам.доллар

Үз-лэлт	Жилээр			Өөрчлөлт				I-XI сар			Өөрчлөлт			
	2016	2017	2018	2017/2016		2018/2017		2017	2018	2019	2018/2017		2019/2018	
				Дүн	Хувь	Дүн	Хувь				Дүн	Хувь	Дүн	Хувь
Эргэлт	8,274	10,536	12,887	2,262	27%	2,351	22%	9,591	11,852	12,639	2,261	24%	787	7%
Экспорт	4,916	6,201	7,012	1,284	26%	811	13%	5,686	6,481	7,056	794	14%	575	9%
Импорт	3,358	4,335	5,875	977	29%	1,540	36%	3,905	5,372	5,584	1,467	38%	212	4%
Тэнцэл	1,558	1,865	1,137	307	20%	-728	-39%	1,782	1,109	1,472	-673	-38%	363	33%

III.1. ЭКСПОРТ

Экспорт **7,055.6** сая ам.долмарт хүрч өнгөрсөн оны мөн үеийн гүйцэтгэлээс **574.8** сая ам.доллараар буюу **8.9** хувиар өссөн байна.

Төмрийн хүдэр, чулуун нүүрс, зэсийн баяжмал, цайрын баяжмал, жонш, молибдений баяжмал, боловсруулаагүй нефть зэрэг уул уурхайн бүтээгдэхүүн нь эрдэс бүтээгдэхүүний экспортын **98.5** хувь буюу нийт экспортын **83.0** хувийг эзлэж байна.

Эрдэс бүтээгдэхүүний экспорт

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	2018 I-XI		2019 I-XI		Өөрчлөлт			
			Тоо хэмжээ	Үнийн дүн	Тоо хэмжээ	Үнийн дүн	Тоо хэмжээ	Хувь	Үнийн дүн	Хувь
1	Чулуун нүүрс	сая тн/сая \$	33.4	2,617.1	34.8	2,943.9	1.43	4.3%	326.8	12.5%
2	Зэсийн хүдэр, баяжмал	сая.тн/сая \$	1.3	1,824.2	1.3	1,671.0	-0.02	-1.4%	-153.2	-8.4%
3	Боловсруулаагүй нефть	сая бар/сая \$	5.7	366.7	6.0	334.8	0.33	5.8%	(31.9)	-8.7%
4	Төмрийн хүдэр, баяжмал	сая тн/сая \$	6.7	307.5	7.6	519.2	0.84	12.4%	211.7	68.8%
5	Хайлуур жонш	мян.тн/сая \$	492.5	165.8	631.0	187.2	138.50	28.1%	21.4	12.9%
6	Цайрын хүдэр, баяжмал	мян.тн/сая \$	113.8	183.6	124.7	175.3	10.82	9.5%	-8.3	-4.5%
7	Молибдений хүдэр, баяжмал	мян.тн/сая \$	5.4	44.5	5.2	45.4	-0.19	-3.5%	0.9	1.9%
8	Хар тугалганы хүдэр, баяжмал	мян.тн/сая \$	20.4	50.7	23.5	53.3	3.10	15.2%	2.6	5.2%
9	Цагаан тугалганы хүдэр, баяжмал	тн/сая \$	25.1	0.3	39.1	0.6	14.04	56.0%	0.3	84.2%
10	Гянтболдын хүдэр, баяжмал	тн/сая \$	701.6	7.4	707.8	6.5	6.16	0.9%	-1.0	-13.1%
11	Боловсруулаагүй буюу хагас боловсруулсан алт	тн/сая \$	3.4	144.5	7.5	344.3	4.03	117.5%	199.8	138.3%

Эх сурвалж: ГЕГ



Чулуун нүүрсний экспорт 2019 оны эхний 11 сард **2,943.9** сая ам.долларын **34.8** сая тн чулуун нүүрс экспортолсныг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулбал үнийн дүнгээр **326.8** сая ам.доллараар, тоо хэмжээний хувьд **1.4** сая тн-оор тус тус их байна. 2018 оны мөн үед 1 тн нүүрсний хилийн дундаж үнэ **78.5** ам.доллар байсан бол энэ онд **84.6** ам.доллар болж өсчээ. Чулуун нүүрсний **98.3** хувийг БНХАУ руу экспортолсон байна.

Зэсийн баяжмалын экспорт 2019 оны эхний 11 сард **1,292.7** мян.тн зэсийн баяжмал экспортолсон нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулбал **18.8** мян.тн-оор бага байна. 2018 оны эхний 11 сард зэсийн баяжмалын экспорт үнийн дүнгээр **1,824.2** сая ам.доллар байсан бол тайлант сард **1,671.0** сая ам.доллар болжээ.

Төмрийн хүдрийн экспорт 2019 оны эхний 11 сард **7,579.9** мян.тн буюу **519.2** сая ам.долларт хүрсэн байна. 2018 оны мөн үеийн гүйцэтгэлтэй харьцуулахад уг бүтээгдэхүүний экспорт **836.8** мян.тн-оор, үнийн дүн нь **211.7** сая ам.доллараар тус тус өсчээ. 1 тн төмрийн хүдрийн экспортын дундаж үнэ **68.5** ам.доллар болж, өнгөрсөн оны мөн үеийнхээс **22.9** ам.доллараар өссөн байна.

Боловсруулаагүй нефтийн экспорт 2019 оны эхний 11 сард **5,997.9** мян.бар буюу **334.8** сая ам.долларт хүрсэн нь өнгөрсөн оны мөн үеийн гүйцэтгэлээс **329.4** мян.бар-иар их, үнийн дүнгээр **31.9** сая ам.доллараар бага байна. Үүнд дундаж үнийн бууралт нөлөөлсөн байна. 1 бар нефтийн хилийн дундаж үнэ **64.7** ам.доллар байсан бол тайланд хугацаанд **55.8** ам.доллар болж буурчээ.

Цайрын баяжмалын экспорт 2019 оны эхний 11 сард **124.6** мян.тн цайрын баяжмалын 1 тн-ыг дунджаар **1,406.1** ам.доллараар экспортолсон байна. Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад хилийн дундаж үнэ **206.4** ам.доллараар буурсан байна. Цайрын баяжмалын экспорт үнийн дүнгээр **175.3** сая ам.доллар болж, өнгөрсөн оныхоос **8.3** сая ам.доллараар буурчээ.

Хайлуур жоншны экспорт 2019 оны эхний 11 сард **187.2** сая ам.долларын **630.9** мян.тн жонш экспортолсон нь 2018 оны мөн үеийн гүйцэтгэлээс **138.5** мян.тн-оор, үнийн дүнгээр **21.4** сая ам.доллараар тус тус өссөн байна. Жоншны экспортын дундаж үнэ **296.7** ам.доллар болж, өнгөрсөн оны мөн үеийнхээс **40.0** ам.доллараар буурсан байна. Жоншийг БНХАУ, ОХУ, БНСУ руу экспортолсон ба **23.8** хувийг ОХУ руу, **76.0** хувийг БНХАУ руу тус тус экспортолсон байна.

Молибдений баяжмалын экспорт 2019 оны эхний 11 сард **45.4** сая ам.доллар болж, өнгөрсөн оны мөн үеийнхээс **0.9** сая ам.доллараар өссөн байна. Тус бүтээгдэхүүний 1 тн-ны экспортын хилийн дундаж үнэ **8,282.6** ам.доллараас **8,750.6** ам.долларт хүрч, **468.0** ам.доллараар өсчээ. 2019 оны эхний 11 сард **5,189.2** тн-ыг экспортолсон нь өнгөрсөн оны мөн үеэс **188.8** тн-оор бага байна. Молибдений баяжмалын **70.1** хувийг БНХАУ руу гаргасан байна.



Алтны экспорт 2019 оны эхний 11 сард **7,464.5** кг алт экспортолсон нь өнгөрсөн оны мөн үеийнхээс **4,032.6** кг-аар их байна. Алтны экспортын дундаж үнэ 2018 оны мөн үед **42,104.9** ам.доллар байсан бол энэ онд **46,121.4** ам.доллар болж **4,016.5** ам.доллараар өссөн байна. Алтны экспорт үнийн дүнгээр **344.3** сая ам.долларт хүрч өмнөх оны мөн үеэс **199.8** сая ам.доллараар өссөн байна.

Коксын экспорт 2019 оны эхний 11 сард тоо хэмжээгээр **124.8** мян.тн болж өнгөрсөн оны мөн үеэс **105.5** мян.тн-оор буюу **6.5** дахин их, үнийн дүнгээр **23.8** сая ам.долларын кокс экспортолсон нь өнгөрсөн оны мөн үеэс **20.1** сая ам.доллар буюу **6.6** дахин их өссөн байна.

III.2. ИМПОРТ

Импорт **5,583.8** сая ам.долларт хүрч өнгөрсөн оны мөн үеийнхээс **212.3** сая ам.доллараар буюу **4.0** хувиар өссөн байна.

Эрдэс бүтээгдэхүүний импорт **1,239.1** сая ам.доллар болж, өнгөрсөн оны мөн үеэс **35.9** сая ам.доллараар буюу **3.0** хувиар өслөө. Эрдэс бүтээгдэхүүний импортын **84.7** хувийг нефтийн бүтээгдэхүүн эзэлж байна. 2019 оны эхний 11 сард **1,049.3** сая ам.долларын **1,661.1** мян.тн нефтийн бүтээгдэхүүн импортолсон нь өнгөрсөн оны мөн үеийнхээс **229.6** мян.тн-оор, үнийн дүнгээр **43.1** сая ам.доллараар тус тус өсчээ. Нефтийн бүтээгдэхүүний импортын **87.9** хувийг автобензин, дизель түлшний импорт, үүний **32.3** хувийг автобензин, **67.7** хувийг дизель түлшний импорт эзэлж байна.

Автобензины импорт 2019 оны эхний 11 сард **471.5** мян.тн автобензин импортолсон нь 2018 оны мөн үеийн дүнгээс **78.4** мян.тн-оор их байна. 2018 оны мөн үед 1 тн автобензины импортын дундаж үнэ **712.3** ам.доллар байсан бол 2019 оны эхний 11 сарын байдлаар **602.0** ам.доллар болж **15.5** хувиар буурсан байна.

Дизель түлшний импорт **989.3** мян.тн болж 2018 оны мөн үеийн гүйцэтгэлээс **225.1** мян.тн-оор өссөн байна. 2018 оны эхний 11 сард 1 тн дизель түлшний импортын дундаж үнэ **673.3** ам.доллар байсан бол энэ онд **618.7** ам.долларт хүрч **54.6** ам.доллар буюу **8.1** хувиар буурсан байна. Дизелийн түлшний импорт өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад **97.5** сая ам.доллараар нэмэгджээ.

Коксын импорт 2019 оны эхний 11 сард тоо хэмжээгээр **1.9** мян.тн болж өнгөрсөн оны мөн үеэс **0.9** мян.тн-оор буюу **2.0** дахин их, үнийн дүнгээр **341.7** мян.ам.долларын кокс импортолсон нь өнгөрсөн оны мөн үеэс **160.1** мян.ам.доллар буюу **1.9** дахин их өссөн байна.